

амьдралын бух салбарт хамтран ажиллах, нөхөр ёсоор харилцан туслах харилцааг бүхий л талаар гүнзгийруулэн хөгжүүлэх болно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд эдийн засгийн социалист интеграцийн зарчим, зорилгын дагуу өөрсдийн ард түмний аж амьдрал, соёлын хэрэгцээг байнга ханган сайжруулах зорилгоор Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн хурээнд хамтран ажиллах явдлыг оролцуулан хоёр талын болон олон талын эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлж өргөжүүлнэ. Хоёр Этгээд социалист эдийн засгийн интеграцийн Цогцолбор Программыг хэрэгжүүлэх үйлсэд хамтран ажиллаж, нөхөр ёсоор харилцан туслах зарчмыг хэрэгжүүлснээрээ Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн гингуун орнуудын эдийн засгийн хөгжлийн төвшинг аажмаар ойртуулан жигдрүүлэхэд бүхий л аргаар тус дөхөм узуулэх болно. Хоёр Этгээд өөрсдийн улс ардын аж ахуйн төлөвлөгөөг удаан хугацаагаар зөвлөлдөн зохицуулах ажлыг ургэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд соёл, шинжлэх ухаан боловсрол, эруулийг хамгаалах, утга зохиол, урлаг, хэвлэл, радио, телевиз, кино, аялал жуулчлал, биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах явдлыг цаашид өргөжүүлэн хөгжүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд хоёр улсын төрийн болон олон нийтийн байгууллагуудын хооронд хамтын ажиллагаа, харилцаа холбоог цаашид хөгжүүлж, хөдөлмөрчдийн хооронд хэлхээ холбоо тогтоон гүнзгийруулэх нь Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард түмнийг ойртуулан нягтруулж, тэднийг тус хоёр орны социалист нийгмийн бүтээн байгуулалтын туршлага, амьдралтай харилцан танилцуулах чухал хэрэгшүүр мөн гэж үзэж бүхий л аргаар тус дөхөм узуулнэ.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд хувьсгалт, дэвшилт бүх хучний гол тушиг тулгуур болсон социалист хамтын нөхөрлөлийн улсуудын нэгдэл нягтралыг улам зузаатган бэхжүүлэх талаар хойшид ч бүхий л арга хэмжээ авч байх болно.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд нийгмийн янз бүрийн байгуулал бүхий улсуудтай энх тайвнаар зэрэгцэн орших бодлогыг тууштай явуулж, олон улсын харилцаанд намжмал байдлыг гүнзгийруулэх явдалд тус дөхөм узуулж, дайныг улс түмний амьдралаас эгнэгт арилган зайлуулахын тулд бололцоотой бүхнийг хийх болно. Хоёр Этгээд хонзогнох, цэрэгжих явдлын аливаа илрэлийн эерэг хамтран тэмцэх болно.

Хоёр Этгээд улс түмний энх тайван, аюулгүй байдлыг империализм, харгислалын түрэмгий хучний хандлага өнгөлзлөгөөс хамгаалан бэхжүүлэх, зэвгээр хөөцөлдөх явдлыг зогсоох, зэвгэгийг бүх нийтээр бүрэн хураах болон колончлолын бүхий л илэрлийг эцэслэн устгахад тус дөхөм узуулэх, колонийн дарлалаас чөлөөлөгдөөн улс түмний үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг узуулэхийн тулд бололцоотой бүхнийг хийх болно.

Долдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд Европын аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар хэлэлцэн тохирсон зүйлсийг чандлан сахих явдлыг дэмжихийн хамт Азийн аюулгүй байдлын асуудлыг энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр шийдвэрлэхэд чиглэсэн бүх хучин чармайлтыг дэмжих болно.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд Баруун Берлинтэй харилцахдаа Баруун Берлин нь Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын бүрэлдэхуун хэсэг биш бөгөөд хойшид ч тууний эрх мэдэлд байхгүй гэдгийг үндэслэн 1971 оны есдүгээр сарын 3-ны Дөрвөн этгээдийн хэлэлцээрийг баримталж байх болно.*

Есдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд олон улсын бүх чухал асуудлаар, туунчлэн тэдний сонирхлыг татсан бусад асуудлаар санал мэдээлэл солилцон зөвлөлдөж, харилцан зохицуулсан байр сууринаас уйл ажиллагаагаа явуулах болно.

Аравдугаар зүйл

Энэхуу Гэрээ нь батлагдах бөгөөд батламж жуух бичгуудийг Улаанбаатар хотноо нэн богино хугацаанд солилцон өдрөөс эхлэн хучин төгөлдөр болно.

Арван нэгдүгээр зүйл

Энэхуу Гэрээг 25 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээдийн аль нэг нь зохих хугацааг дуусахаас арван хоёр сарын өмнө уг Гэрээг цуцлах тухайгаа эс мэдэгдвэл арав арван жилээр аяндаа сунгагдаж байна.

Энэхуу Гэрээг 1977 оны 5-р сарын 1 өдөр Берлин хотноо герман, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх нь адил хучинтай байна.

БҮГД НАЙРАМДАХ
АРДЧИЛСАН ГЕРМАН
УЛСЫН ӨМНӨӨС
Э. Хонеккер

БҮГД НАЙРАМДАХ
МОНГОЛ АРД УЛСЫН
ӨМНӨӨС
Ю. Цэдэнбал